

УДК 930.85+294.3

СҮМБЭ ХАМБА ИШБАЛЖИР ЛАМЫН “ГҮРҮ ЁГО БУЮУ БАГШИЙГ БЯСАЛГАХУЙ” ЗОХИОЛЫГ ШИНЖЛЭХ НЬ

Усгал Б.

МУИС-ийн Шинжлэх ухааны сургуулийн Утга зохиол,

урлаг судлалын тэнхимийн докторант

E-mail: 187054746@qq.com

Хураангуй

Энэхүү номын бүтэн нэр нь “Багшийг бясалгахуй ёсон-Шид бүтээлийн хүү сан хэмээгдэх оршвой” нэртэй бөгөөд товчлон хураангуйлбал “Гүрү ёго буюу Багшийг бясалгахуй” нэрт бүлгээ. Уг зохиолыг өмнө нь монгол хэлэнд буулгаагүй бөгөөд анх удаа төвөд хэлнээс монгол хэлэнд буулган тусгай өгүүлэл болон шинжлэн судалснаа энэхүү өгүүлэлдээ танилцуулж байна. Уг зохиол нь, Бурханы шашны нэн нарийн утга хэрэг болох Багшийг бурханчлан бясалгах ёсны ном бөгөөд багшийг бурханчлан бясалгаснаар бүхий л бурхдын эрдэм чадал, мэдлэг ухааныг өөртөө шингээж авна гэсэн утга санааг илэрхийлж байна.

Түлхүүр үг

Сүмбэ хамба Ишбалжир, Багшийг бясалгахуй, бурханы шашин.

UDC 930.85+294.3

ANALYSIS OF SUMBE ABBOT ISHBALJIR LAMA'S "GURU YOGA, OR THE CULTIVATION OF THE TEACHER"

Usgal B.

Department of literature and Art Studies, Faculty of Science, MSU

E-mail: 187054746@qq.com

Annotation

The full title of this book is "meditating the teacher yesong-the son of the Shid creation San," and the short title is "Guru Yego, or meditating the teacher". The text has not been translated into Mongolian before, and for the first time it has been translated from Tibetan into Mongolian as a special article and is presented in this article. The text is a book on the divine cultivation of the teacher, which has a very complex Buddhist meaning, and it expresses the meaning that by the divine cultivation of the teacher, the knowledge and knowledge of all the gods will be absorbed.

Key word

Sumbe Abbot Ishbaljir, meditating the teacher, Buddhism.

О Р Ш И Л

Сүмбэ хамба Ишбалжир бол 18-р зууны үеийн Хөх нуурын төр шашны том зүтгэлтэн. Тэрбээр ойрадын язгууртан гаралтай хүн. Монгол төвд анагаах ухаан, түүх, шашны гүн ухаан, одон орон судлал, зурхайн талаар ажиллаж, олон бүтээл туурвисан нэрт түүхч, зохиолч байжээ. Өнгөрсөн зууны 50-ад оноос эхлэн дотоод, гадаадын монголч эрдэмтэд Сүмбэ хамба Ишбалжирын тухай бичиж байсан (Бира, 2020; Бадрал, 2024; Востриков, 2015; Гарри, Жабон, 2021; Пубаев, 1976; Царс, 2015; Шү Лин, 2016; J. W. de Jong, 1967; Rosenthal, 2004; 额尔敦白音, 2020; Ишбалжирийн Бурхан шашны түүх, 1993).

«Хөх нуурт төрж, Амдогийн Гонлун хийдийн хамбаар насан элтлээ суусан хошууд аймгийн тайж гаралтай монгол хүн, нэрт соён гэгээрүүлэгч, шашны зүтгэлтэн Сүмбэ хамба Ишбалжир (1704-1788) түвэд зурхайн 14-15-р зуунд бий болсон пүг, цүр гэх хоёр өөр ёсны шимийг нь авч монгол газрын хуваарьт тохируулсан шинэ зурхай бий болгосон нь “Төгс буянт шинэ зурхай”» (Галаарид, 2023). Түүний зурхайн чиглэлээр хийсэн ажлыг эрдэмтэд судалж, суралцаж, илүү зүйл мэдсэнээр зурхайн ухааны тухай бодохдоо, хуанли тухай судалгаа хийхдээ ашигладаг (Омакаева, 1995).

“Гүрү ёго буюу Багшийг бясалгахуй” нэрт ном нь үндсэн хоёр сэдэвтэй. Үүнд:

1. Багшийг шүтэх нь ямар хэрэгтэйг олон зүйлийн ном судраас эшлэл татаж өгүүлжээ.

2. “Багшийг бясалгах ёс”-ыг бүрэн зааж өгсөн байна.

I. Багшийг шүтэх нь ямар хэрэгтэйг олон зүйлийн ном судраас эшлэл татаж өгүүлэхдээ Бурхан багшийн айлдсан билэг барамидын судар болох “Эрдэм эрдэнийн хураангуй” хэмээхэд “Мэргэд бээр багшийг үргэлжид шүтэн үйлд” гэсэн ба “Таван зэрэгт” хэмээх шастираас “Тахил бүгдийг тэвчээд багшийг гагцхүү тахихыг хичээн туурви” гэсэн ба “Бүхий хамаг увдисыг хураахын үүд эх нь багшийгаа үл алдах мөн” гэх мэтээр судар шастираас эх эшлэл авч дурджээ. Тухайлбал:

Бүгдийн ганц эцэг гэтэлгэгч Манзушри бээр сургаалын багш Баатар Очир болон Богд Зонхова, төгс онолт Жамбалжамц тэрхүү гурав дор бодитой соёрхсон нууц номын нэгэн Багш дор шүтэх хэрэгтэй ёс тэргүүтнийг ерөнхий өгүүлэх ба багшийн иогийн зэргэмж бодитойг өвөрмөц дор өгүүлэх болой.

“Эрдэм эрдэнийн хураангуй”-гаас: “Багш мэргэд нугуудад үргэлжид шүтэн үйлд” хэмээсэн.

“Таван зэрэг”-ээс ч: “Тахил бүгдийг огоом тэвчээд багшийг тахихыг ч үнэхээр туурви” хэмээн номлосон.

“Хөх дэвтэр”-ээс ч: “Увдис бүгд хураахын эх нь дээд багш садныг үл алдах мөн” хэмээсэн.

Паадамба бээр ч “Багш бурхныг оройн зулайн чимэг мэт хэзээ ч хагацал үгүй дадуулагтун, аглагт бясалгагч аа” хэмээн номлосон.

Бодава гэгээн бээр ч “Тийн гэтлэхүйг бүтээхүйд багшаас хэрэг ихтэй нь үгүй” хэмээсэн.

Богд Зонховын гэгээн бээр ч “Эрдэм бүгдийн ёзоор ачтан богдыг” хэмээн номлосон.

Энэ бүгдээс үзвэл хойдын сайн буян сайн амгалан бүгдийн үндэс нь “багш мөн учраас гэтлэхийг хүсэгч нугууд бээр анхан дор бэлгэ шинж төгөлдөр нэгэн багшийг шүтэх хэрэгтэй бөгөөд Нараво бээр “Галбын мянган бурхан нь ч багш нугуудад шүтээж гарсан” хэмээн бурхан бодисадва бүгд ч өөр өөрийн багш нарт шүтээж газар мөрийг олсон” хэмээн номлосон. Тэгэхээр энэ номын нэн чухаг санаа нь хэн бээр боловч багшийг шүтээж эрдэм номын оргилд хийгээд өөрийн зам мөрийг чигч шулуун болгоход дэмжлэг туслалцааг авсан нь гагцхүү багшаас эхтэй” хэмээн хэлж өгчээ.

Мөнхүү цааш нь “Самбода”-гаас: “Алины тулд арван зүгийн бурхан хийгээд бодисадвагийн буянаас сургаалын багшийн шар үсний нэгэн нүх дээд” хэмээн өөрөө бээр чуулганыг хураахын орон дор бурхан бодисадва бүгдийг тахиснаас өөрийн үндэсний ламын шар үсний нэгэн нүхийг тахисан нь үлэмж” хэмээн номлосон нь арван зүгийн бурхдыг тахихын өмнө өөрийн багшаа тахин шүт буюу утгаа багшийн шар үсний нүх мэт жижиг зүйлсийг ч үл умартахыг сануулж өгчээ.

Майдар бээр: “Өргөж хүндлээд, олз нугууд хийгээд тахимлаг хийгээд бүтээхийн үүднээс багш садныг шүтээж үйлд” хэмээсэн ба “Ламын тавин шүлэгт”-ээс ч: “Сургаалын багш лүгээ Очирьг баригчийг ангид тусад нь үл шинжилмүй” хэмээн номлосон бөгөөд Бром номын хаан бээр ч “Би бээр хааш яашиар ламыг шүтээж үзээгүй, шүтээд агишин зуур ч халилд хаяж үзээгүй” хэмээн номлосон ба Харог-Гомчун бээр ч: “Их хөлгөнийг заагч ламын гадаад явдал үзэсгэлэн бус болов чиг дотоод таалал бодлыг үл мэдэх учраас багшийн гэмийг үл ажиглагтун зэ” хэмээсэн ба “Бишрэл сүсгийг хатуу үйлдэгтүн зэ” хэмээн номлосон нь монголын аман ярианд уламжлагдан ирсэн нэгэн үг байдагтай утга нэгэн аж. Тухайн хүнийг өөрийн багш болгохын урд тулгал хард, шинжил харин нэгэнт багш болгон өргөсөн бол багшийн үгийг хэлбэрэлтгүй дагаж, сүслэн мөргөж, багшийн гэмийг үл ажиглан хатуу сүсэглэн шүтэж суралцах хэрэгтэйг сургасан байна.

Хэрхэн багшийг шүтэж ном эрдэмд суралцаж, бясалгах тухай:

Орон сэтгэл зохист бөгөөд тэгш баясгалантай дор самади дияаны байшингийн гадна дотно бүгдийг цэвэрлэж сайтар үйлдээд, Богд лам болон Бурхан багшийн хөрөг тэргүүтэн гурван шүтээнийг дэлгээд, түүний өмнө тахилын эд ариун бөгөөд сэтгэл зохист, үзэсгэлэнгийн ном, албын ном тэргүүтэн дор үл одуулан бэлтгэ. Олбог дэвсгэр дээр шүтээн руу зүглээд ёс зохистойгоор суумуй.

Хоёрдугаар бодит суурь дор гурав. Барилдлагат дөрвөн номыг анхааран авах, лагшин, зарлиг, таалал, эрдэм үйлс лүгээ сэлтийн адистидыг айлтгах, нийтийн мөрийн зэргийг бясалгах болой.

Мөр, тогтсон таалал буруут хийгээд доордоос ялгамжаат дор болсон бөгөөд үндэс сав дор болохуйг бүтээхийн хэрэг дор аврал одуулах бөгөөд цаглашигүй дөрөв ба сэтгэл үүсгэхийг бясалгах, зохилдох нөхцөл чуулган хураахын тулд мандал өргөх, харшлах шалтгаан хилэнц уналыг арилгахын тухай дор Базарсадыг бясалган урих лүгээ тотгороос хамгаалахын тулд сахиусан хүрдийг бясалгах, адистидыг түргэн оруулахын тулд гүрү иогаг бодитой бясалгах болой.

Ийнхүү бясалган суухдаа хэрхэн аврал одуулах, ямар тарни унших тухайтад:

Аврал одуулгын дөрвөн аймаг, зургаан аймгийг үйлдэх ба цаглашигүй дөрвийг өмнө одуулгатны сэтгэлийг үүсгэх ба хоёрдугаар чуулганы орон дор мандал гучин долоот, хорин гуравт, ест, долоотыг хэр зохистойгоор өргөх ба гуравдугаар өөрийн орой дор Базарсад эцэг эхийг бясалгаад, бусдын хэргийн зоригдол гурав лугаа

өөрийн хэргийн зоригдол гурав алин зохист лүгээ сэлтийн үүднээс “Зуун үсэгт” тарниаг хорин нэг тэргүүтнээр үйлдэх ёс нугуудыг үсэг олондох учраас айгаад дэлгэрэнгүй бичихгүй учраас нийтийн одуулга мэт өмнө хандуулмуй за. Сахиусан хүрд нь. Өөр ямагт Очирдар буюу Манзушир тэргүүтэн бурхан болж тодорсны зүрхний Хум үсгээс Хум үсэг цаглашигүй цацраад биеийн гадна дотно бүгдэд түгснээр биеийн тоос нарийн бүдүүн бүгдээр очирын мөн чанартай болоод шар үсний үүдүүдэд дор оршсон хум үсэг огоот арилснаас, хөх өнгөтэй, таван үзүүртэй хөх өнгийн очирын байдалтай болбой. Бас дахин зүрхний Хум үсгээс хөх гэрэл арван зүгт цацарсны үзүүрээс очирын тоос нарийн бүдүүн хэмжээлигүй гарснаар очирын газар дэлхий, гэр хүрээ, лавир лүгээ сэлт болбой хэмээн санах бөгөөд аманд ч Хум буюу Ом Базар Рагча Рагча Хун пад суухаа хэмээх болон дэлгэрэнгүй үйлдвээс Базарын оронд Бадмаа болон Чакра болон Хадамга болон Саразала болон Зула хэмээхүүдийг зэргээр найруулах бөгөөд очир хүрээний гадна талд зэргэмжээр лянхуа, хүрд, илд, сум, галын гэр бясалгаад, тотгор хийгээд зэтгэр барцдаас хамгаалж үйлдтүгэй. Үргэлжид ч үүн лүгээ үл хагацуулан үйлдэх нь хэрэг ихтэй. Мөнхүү бас “Дадьяата, шамэ, шама бадэ, ша ламда, шадрүм, Ом гүрэ, ман гүрэ, мара зиди, гаради, гиюүрэ, огха бадди, охога мадэ, бишата, нирмалэ, мала бана еэ, о харэ, охарэ дамэ, хаяа, дасэ дасанэ, хээ махи, бара мүхи, шамидани, сарва дата, бандха нани, ниди хида, сарва бара, бра бадина, би мүгдэ, мара баиша, табита, буддха, маха самудгади да, сарва мара, аза лида, бара бари, буддха ди, газцандү, мара гарма ни” хэмээх шимнусыг гэсгээн таслах тарни ба “Дадияата, Ом базар занда мохорахана хум пад, абри дихада, бала хум пад, сарва бигханан дара яа, бинаша, гара, мара яа хум пад” хэмээн тотгорыг амарлиулан үйлдэгч тарни тэргүүтнийг ч уримуй.

Язгуурын багшийг уран сайхнаар дүрслэн өгүүлэхдээ:

Сансар нирвааны ном бүгд өвөрлөнгөөр хоосон чанартай ба өмнийн огторгуй дор тахилын үүл жигдэрсний төв дунд, найман их арслангаар өргөгдсөний эрдэнийн ширээн дээр элдэв лянхуа, наран дүгрэг дүүрэн дэлгэрсний дээр, Дхи үсгээс илд дхи үсгээр машид тэмдэглэгдсэнээс, язгуурын багш лугаа үлэмжийн бурхан ялгалгүй Манзушир лам Зонхаба, цагаан дор улаан өнгө төгөлдөр, мишээхүй нигуурт, алтан өнгөт баншу малгай, эл шарын өнгөт номын хувцсыг өмссөн, баруун мутар номыг заасан, зүүнийг тэгш агуулсны дээр, рашаанаар машид дүүргэсэн бадар аяга, үзэсгэлэнт суварга, хоёр мутрын эрхий долоовороор удвал цэцгийн шийг чимхэн барьсан, машид үзэсгэлэнт навчис нь сонорын харалдаа дэлгэрсний дээр, билгүүний илд билиг барамидын ботийг бэлгэдсэн, лагшин найргийн чимгээр хээлж, таван өнгийн солонгон хүрээний төвд, хоёр өлмий очир завиллын ёсоор суусан. Түүний орой дор лянхуа саран дор Манзушири, гүргүмийн өнгөт, илд боть барьсан, таван шанх төгөлдөр, эрдэнийн торго магнагаар чимэглэсэн, лагшин найргийн үзэсгэлэнт чимэгт, солонгын дунд завиан суусан. Хоолойд лянхуа саран дээр Локишвара цагаан, үндсэн хоёр мутар алга хавсарсан, доодсоор эрих лянхуа барьсан, эрдэнийн торгон хувцас, гөрөөсний арьсаар чимэглэсэн, лагшин найргийн чимгээр үзэсгэлэнт, солонгын гэрийн төв дор суусан. Зүрхэнд лянхуа наран дэвсгэр дээр нууцын эзэн очирваань индранил өнгөт, догины дүрт, очирьг бариад занан зүхэх хурууг гаргасан, эрдэнийн торго болон могой чимэгт, галын цогцсын төв дунд зүүнийг жийсэн байдлаар оршсон түүний зүрхэн дор лянхуа саран дээр нарны садан, замбутивийн алтан өнгөт гурван зүйлийн номт хувцсыг өмссөн, газрыг дарахуй, тэгш агуулахуй,

биндэрьяа бадар аягыг барьсан, лагшин найргийн чимэг үзэсгэлэнтэйеэ, солонгын төв дунд очир завиллаар оршсон. Тэр ямагтын зүрхэн дор лянхуа наран дээр Очирдара, лагшин өнгө машид хөх, очир хонх барьсан, эрдэнийн найман чимэг, торгон баринтгийг соёрхсон, лагшин найргийн чимэг үзэсгэлэнтэй, солонгын төв дунд завилаан суусан. Таван орон дор таван хөрөнгө үсгээр машид бэлгэдсэн, хум үсгээс гэрэл туяа долоо лугаа дээд зүг, баруун, зүүнд цацарсны үзүүрийн лянхуа тэргүүтэн дэвсгэр тус тусад, язгуурын багштай уулзах цагийн байдалтнууд, Очирдара дор адистидын дамжлага ба Майдар Манзушир агуу их гүнзгий дамжлага сэлт, захаар нь тойрон ядам тэргүүтэн хүрээлсний Хум үсгийн гэрэл бээр авралын орон бүхнийг урин залж ялгалгүй бат оршвой хэмээн санана. Мөн бас язгуурын багш Зонхова тэргүүтний байдал дор хувиргалгүй уулзах цагийн байдал дор үүсгэхийг хүсвээс бусад ихэнх дор адил бөгөөд ялгамжаа нь тэргэл дүүрний дээр хэмээхийг залгуулаад язгуурын багш огторгуйн Сайн огторгуйн цог хэмээх мэт өөрийн язгуурын багш алин мөн болохын алдар нэр лүгээ найруулаад тэндээс үлэмжийн бурхан лугаа ялгалгүй гурван аврал бодитой, цагаан дор улааны өнгө төгөлдөр, мишээхүй нигууртай, алтан өнгөт баншү малгай, эл шарын номт хувцсыг өмссөн, баруун мутар номыг үзүүлсэн, зүүнийг тэгш агуулсны дээр бодь мөрын зэргийн ботийг барьсан хэмээх мэт өөр дор ном аль нэг заасны ботийг найруул. Түүний дараа лагшин найргийн чимгээр үзэсгэлэнтэй, таван өнгийн солонгын төвд, хоёр өлмий очир завиллын ёсоор суусан. Түүний зүрхэн дор лянхуа саран дор Нарны садан хэмээх тэргүүтнээс доош адил. Мөнхүү бас авишгийг соёрхсон очирт суртгаалын багш мэт дор болбоос, “дүүрэн тэргэлийн дээр” хэмээхийг залгуулаад, Очирдарын эрхт Хэлний эрхт дээд төгөлдөр цогт хэмээх мэтийг найруулж болох бөгөөд цагаан дор улаан туяа тогтсон мишээхүй нүүртэн, таван язгуурын титэм, унжлага, хос хувцсыг өмссөн, баруун мутар таван үзүүрт алтан очир, зүүнээр цагаан өнгөт мөнгөн хонхыг бариад цохьсон, лагшин найргийн хэмээх тэргүүтнээс доош адил болой. Тэдгээрийн алиныг ч үйлдсэн болов, түүний дараа, Бурхан бүгд хурсны лагшин, Очирдара бурхны мөн чанарт, Гурван эрдэнийн үндэс бөгөөд Багш нугууд дор мөргөмүй. Ийнхүү багшийг уран яруу дүрслэн хэлж шавь хүн багшийг хэрхэн шүтэн мөргөж, буян дор даган баясахыг ч мөн заан хэлж өгчээ.

II. “Багшийг бясалгах ёс”-ыг бүрэн зааж өгсөн байх бөгөөд үүнд бас дотроо задарч, хоёр дэд сэдэвтэй агаад тэр нь:

1. Багшийн бие, хэл, сэтгэлийн адис хүчийг дэлгэрэнгүй бясалган бодох арга,
2. Багшийг тарнийн номын дөрвөн их эрх авшиг, тарнийн хоёр зүйл зам мөрийн аргачлал лугаа холбож өгсөн бөгөөд үүнд эхний дэд сэдвийг нийтээр бүтээж болох бясалгал гэж үзэж, хоёр дахь дэд сэдвийг нийт бусын буюу тодорхой авшиг эрх авсан хүн бясалгах ёстойг зааж өгчээ.

Багшийг бие, хэл сэтгэлийн хүчийг хэрхэн удирдан зохицуулж бясалгах тухай дараах мэтээр бичсэн байна. Тухайлбал: “Агшин нэгээхэн дор ургуулагч алин Багш эрдэнэ мэтийн лагшинт Очиртны өлмий лянхуа дор сөгдмүй. “Үзүүлэгч ханьцашгүй” хэмээхээс “мөргөмүй” Гурван мянганы тоос тэнцүү биеэ хувилгаж мөргөж тахмуй Дөрвөн хүчээр хүчээр хилэнцийг наманчилж, буян дор даган баясмуй. Зуун галав дор батад оришиж, амьтнаа номын хурыг буулгагтун. Гурван цагийн буян бүхнийг их бодийг олохын тулд зориулмуй хэмээн долоон гишүүнт ба “Өөр бусдын бие хэл” хэмээх тэргүүтнээр мандалыг ч өргө. Тэндээс, Гол эрхмийн зүрхний хум үсгийн

гэрэл бээр Нөхөд нугууд толин дахь үлээлт мэт Гэрлийн байдлаар гол эрхэм дор хурж Багш орой дээр заларч ирээд суувай хэмээн санаад авралын орон бүхэн хурсны мөн чанартай түүнээ сэтгэлээ алгасруулалгүй Цог төгөлдөр язгуурын багш эрдэнэ Миний орой зулай дээр лянхуа саран дэвсгэр дээр суугаад Зарлигийн их ачийн үүднээс даган барьж Лагшин, зарлиг, тааллын шидийг өршөөн соёрх”.

Мөн цааш нь Лагшин, зарлиг, таалал, эрдэм, үйлс лүгээ сэлтийн адистидыг айлтгах нь. “Багш авралын орон бүхэн хурсан бээр Лагшин, зарлиг, тааллын адистидыг өршөө хэмээн гурван удаа залбирал тавьснаар Багшийн орой дээрхи Ом үсгийн гэрэл цагаан өнгөөр мэлмэрээд Ом үсэг хийгээд цагаан өнгийн рашааны урсгал лугаа тоолиггүй лагшин гарч ирээд өөр бусдын орой зулайгаар бие дор сайтар шингэснээр Аяа бясалгал дор эрхшээлийг олж, лагшны адистидыг олвой. Багшийн хоолой дахь Аа үсгийн гэрэл улаан өнгөөр тунараад Аа үсэг лүгээ хамт улаан өнгийн рашааны урсгал хийгээд тоолиггүй тарни Гарч ирээд, өөрийн хоолой зүрхэн дор сайтар шингэснээр Зарлиг тарни тоолохуй дор эрхшээлийг олоод зарлигийн адистид олвой. Багшийн тааллын Хум үсгийн гэрэл, хөх өнгөөр тунараад, Хум үсэг лүгээ хөх өнгийн рашааны урсгал хийгээд мутрын тэмдгийн чуулган Гарч ирээд, өөрийн зүрхэн дор асгаран буугаад, сайтар шингэснээр Самади бясалгалд эрхийг олоод тааллын адистидыг олвой. Таван язгуурын хөрөнгө таван зүйл гэрэл туяа цагаан, улаан, хөх, шар, ногоон дор тунамалзаад, Таван үсэг, таван рашааны байдлаар гарч ирээд, таван оронд шингэснээр Бие, хэл, сэтгэл нийтийн дөрвөн түйтгэр арилаад, дөрвөн авигийг олоод дөрвөн лагшны лагшин зарлиг таалал ялгалгүй Хөрөнгийг сайтар мэндлүүлж, багш хоёрдугаар бээр өөр дор шингэв хэмээн санаад, багшийн тааллын наран дэвсгэр дор Хум үсэг хийгээд өөрөө нэгээхэн эгшинээр Шакъяамүни бурхан багш болж тодорсны зүрхний саран дэвсгэр дор цагаан өнгийн Ом /Манзушир дор болбоос Дхи/ үсгийн гадуур тарнийн эрихс байрлахуй болбой хэмээн санаад Ом Аа Гүрү Базар дара Хум хэмээх лүгээ “Мүни” тарнийг хорин нэгэн удаа тоолж урих бөгөөд түүгээр жишээд, өөрийн шүтээн бурхан бусад дор ч найруулах ёсыг ч хялбар мэдэх болой”.

Нийтийн мөрийн зэргийг бясалгах нь. Гурван төрөлхтний мөрийн зэрэг бусдаас гарсан адилаар дэлгэрэнгүй бясалгаад, мөн бас холбож барилдуулах цаг дор бүлэг хуваарийг дүүргэхийн тухайд ерөөл лүгээ холбож үйлдвээс энэ мэт болно. Өөр бусдын гурван үүдний буяны чуулган гурван мянганы хүсэл бүхнийг өргөмүй. Залбирал, өөрийг эрхэмлэн барихуй, үнэнд барих тэргүүтнийг түртгэмүй.

Мөн энэхүү номд багшийг эс шүтэх, ном эрдэлд үл суралцах хийгээд энэ болон дараа төрлийг олоход чухам юунд гэмших тухайтад өгүүлсэн хэсэг буй. Тухайлбал:

“Магад гарахуй, цаглашгүй, бодийн сэтгэл, зургаан барамид, хураахуй дөрвөн бодис Амарлих үлэмж хослон барилдсаныг үндсэн дор төрөхүйд адистидла хэмээн мандал өргөөд залбирлыг тавих бөгөөд Бэлгэ чанар төгөлдөр багш нугуудаас сайн номлолын эрдэнэ Машид олныг олсон болов чиг усны шүүр ямарчлан гэмийг бариад Бурхны хуран мэдэл үгүй дор гэмшмүй, нигүүлсэн болгоо.

Хойшид санаа барилдлага хоёроор ёсчлон шүтэх болтугай. Олоход бэрх хэрэг ихтэй чөлөө учрал шүтээнийг олж, бурхан шаашин лугаа Учирсан боловч зэгс мод лугаа адил орчлонгийн амгалан дор шунаснаар насыг Уулын уруу буух ус мэтээр үхлийг нэхэн одсондоо гэмшмүй, зэ.

Нэгэн удаа төдий олдсон шүтээн үүн дор шимийг авах болтугай. Үхэх дор магадтай бөгөөд хэзээ үхэх нь болзоо үгүй үхсэнээс ч өөрөө гагцаар Тэнэж одох цагт номоос бус, эд тэргүүтэн юугаар ч Тус үгүй боловч сансрын амгалан дор шамдсандаа гэмшмүй, зэ.

Үхлийг дурдаад эдүгээгээс ном дор хичээхүй болтугай. Тамын арван найман орон, гурван зүйл бирд тэргүүтэн, адгуусны язгуур Хоёр тэргүүтэн найман чөлөөгүйн зовлон гэм эрүү нугуудыг Эс дурдан өдөр шөнийг хэрэггүй өнгөрөөсөндөө гэмшмүй, зэ.

Орчлонгийн аюулаас аврагч дор оюуны мухрыг тушаах болтугай. Энэ завсар дор аврал одуулгыг олонтоо үйлд. Ургац жимсэн дор тэнцэхүйц цагаан хар үйл үр тус тус дор өгөгч, Магадтай арвижих, эс үйлдсэнтэй үл учрах, үйлдсэн шамшаагдахгүй дор Сэтгэл итгэмжлэхээс хагацаад, авал орхилыг эс үйлдсэндээ гэмшмүй, зэ.

Үүнээ, “Зургаан үүдтийн тарни”, “Уналыг наминчлахуй”, “Нийтийн наминчлал” тэргүүтнээр дөрвөн хүчийг бүрдүүлэн үйлдэх бөгөөд үүнээс урагших нь бага төрөлхтөн лүгээ нийтийн номын аймаг болой. Сансрын далай дор үйл нисванисын эрхээр хаана төрөхүй болов чиг Төрөх, өтлөх, өвдөх, үхэх зовлон, найм, зургаа, гурав нугуудаар Нэрмэгдэх ёсыг эс санан, орчлонгийн амгаланд шунасандаа гэмшмүй, зэ.

Гурван орчлон, дөрвөн сансарыг өргөст гуу, гяндан адил дор үзэх болтугай. Товчилвоос, зовлон бүхэн гарахуй хоёр буюу арван хоёр шүтэн барилдлагаар Орчлон дор галын тойрог, наран саран ямарчлан орчдог ёсыг Сайтар санаж, галын нурам мэт үзэж, түргэн нирваанаа хүрэхийн тулд Зүрхнээс буяны арван цагаан ном, гурван суртал дор шамдах болтугай” хэмээн сургажээ.

Мөн хүний зам мөрийг ч залан чиглүүлэхэд тустай хэд хэдэн шад мөрийг холбон бичсэн байна. Үүнд:

- Амьтан бүхэн эх минь болж байсан нь магадтай, их ачтай тэд бүгд ч Амгалан хүсэж, зовлонг үл хүсдэгээрээ тэд бүгдийн Зовлонг арилгаж, амгалан жаргаланд байгуулахын тулд бурхны хутгийг түргэн олох болтугай.

- Үүн дор “тэгш хандахуй”-г өмнө нь удирдуулсан дөрвөн цаглашгүйг гурван удаа бясалгаад, бодь дор сэтгэл үүсгэнэ. Тэндээс, бодисадвын санваарыг “Бодисадвын явдалд орохуй”-гаас гарсан мэт дагуу гурвантаа өгүүлж авна.

- Авлага үрийг горилох үгүйгээр, хармаас хагацсан дөрвөн өглөгийг өг. Дурдал мэдэмсэр, сэрэмж мэдэмсэр, ичгүүр, бишрэл сүсгээр шагшаабадыг сахь.

- Уур хилэн, залбирлыг дарахын тулд, асралыг өрнүүлэн, тэсвэр хичээнгүйг шүт.

- Хураангуй дөрвөн бодос тэргүүтэн бодисадвагийн явдал дор хичээх болтугай.

Энэ хүү зам мөрийг энгийн хүмүүн боловч сэтгэлдээ багтаан бясалган, санаж сэрж явах учиртай аж. Өөрөөр хэлбэл бүхий амьтад өөр хоорондоо уялдаа бүхий шүтэн барилдлагатай тул бүхий л амьтадыг энэрэн нигүүлсэн хайрлах тухай сургажээ. Мөн хүн хийгээд бүхий амьтадад тэгш хандаж, ялгаварлахыг цээрлэхийг мөн бусдад өглөг өгөх тухай тэр дундаа авлаг үрийг горилохгүйгээр өглөг өгөх тухай сургажээ.

Тус номын төгсгөл хэсэгт дараах мэтээр дурдсан байна.

“Энэ төдийг үйлдэхүй дор цог төгөлдөр язгуурын багш их эрдэнэ миний зүрхэнд мөн бус болбоос орой тэр судал хүрдний төв хэмээх тэргүүтэн үгүйлээд санаад зориулах ерөөлөөр завсрыг найруулаад хоосон чанарын үзлээр дэлгэрэнгүй талбимуй.

Нийт бусын багшийн ёго, дөрвөн авшиг, хоёр зэрэг сэлтийн анхааран авлага дор гурван адистидыг оруулахын тулд багш Очирдара шүтээн шүтэгдэхүүнийг бясалгаад залбирлыг талбих, тарнийн санваарыг сэргээх тэргүүтний тухайд дөрвөн авшиг өөрөө орохуйн ёсон дор товч хураангуйгаар авах, тарнийн мөр дор авьяас баттайг агуулахын тулд хоёр зэргийн үүсвэр, бясалгах ёс болой.

Очирдара эцэг эх тэгш орсны баясгалангийн дуугаар эцэг эх бурхан хэмжээлшгүйг урин залаад багшийн орой зулайгаас оршоод их нигүүлсэхүйн галаар хайлсан бодь сэтгэл багш эцэг эхийн завсар найруулгаас гараад өөрийн орой зулайгаар оршоод биеийг дүүргэснээр энх амгалангаар түгээд өөрөө очир хонх лугаа хамтаар Видяа эхийг тэвэрснээр амгалан хоосон бэлгэ билгүүн сэтгэл дор төрөхүй болвой хэмээн санахуй лугаа сац сургаалын багшийн эрх авшиг, Огторгуй дор орисон авшигийн бурхад нугууд бээр Ом сарва дата гада ави хи гада самъеэ ири еэ хум хэмээн орой зулайгаас рашааны усаар авшиг өгснөөр бие дүүрч их амгаланг амсвай.

“Багшийг бясалгах увдис-Гүрү иога”-гийн увдис нь, увдис бүхний эрхэм гол мөн бөгөөд Богд ламын “Бодь мөрийн зэрэг”-ээс: “Багш садныг шүтэх номын аймаг эдгээр нь алинаас ч хэрэг ихтэй, ашдын хэрэг хүслийн үндэс гэж үзэгдэхийн учир” хэмээн номлон айлдсан мэт бөлгөө.

Тийм мэтээр бус дор өчүүхэн нэгэн увдисыг бариад багшийг ёсчлон шүтсэн, эс шүтсэний ач тус ба гэм эрүүг болон шүтэх ёсыг эс мэдсэн атал “Гүрү иога”-г хийж буй мөн хэмээгээд “Багшийг тахихуйн зан үйл”-ийн үг үсэг нэжгээд төдийг уншсанаар хаана ч үл хүрэх бөгөөд мөнхүү бас түүнээс “Гүрү иога хэмээн огоот алдаршсан увдис нь ч өмнө номлосон мэт ухаарах хэрэгтэй буй за, зорилго нэжгээд хувь төдийг судалснаар хаана ч үл хүрэхүй дор” хэмээн номлосон болой. Тэрчлэн шүтсэн, эс шүтсэний эрдэм болон гэм тэргүүтнийг сайтар мэдэж санасны үүднээс багш өөрийн нь ойр орчимд суух аваас “Модны байгууллын судар” болон “Багшийн тавин шүлэгт”-ээс номлосон мэт гурван үүдээр өргөж хүндлэх ёс зохилдонгуйг ч үйлдэх бөгөөд сууж буй үгүй алин мөн дор ч дөрвөн хувь тасалгаат буюу зургаан хувь тасалгаатаар үйлдэж, багшийн адистид орисоны шинж тэмдэг адаг наад зах нь зүүднээ ч гарахыг хүртэл Гүрү иога дор шамдаад анхааран авах хэрэгтэй бөгөөд мөнхүү бас түүнээс “Шүтсэний тус эрдэм бурхныг олох тэргүүтэн хийгээд” хэмээхээс “Тэр мэт тэр бээр үүр, өглөө болон үдээс хойш, үдэш лүгээ дөрвөн хуваариар бясалгаж үйлд” хэмээн номлосон бөгөөд урьдын дээдэс нар бээр ч буяны найруулгын гурван хувь нь Гүрү иога мөн хэмээн номлосон болой хэмээн Гүрү иога нийт хийгээд нийт бусын судар тарнийн мөрийн зэрэг, өөрөө орохуй лугаа сэлтийн хувь бүрэн агаад эндүүрэггүй, шид бүтээлийн гуу сан хэмээгдэх үүнийг нь

Гонлүн Жамбаалин хийдийн улири ловон Лодойжамцын хувилгаан айлдал билгүүн машид уужим Пунцагданзанжамц бээр шамдаж дуртгасанд шүтээд, Шакъяагийн аягха тахимлиг Ишбалжир бээр улаан нүдэн /модон хулгана/ жилийн зуны дунд сарын цагаан зүгийн ялгуулсан хоёрдугаар өдөр даруй найруулсаны бичээч нь буяны зүгт сайтар хичээгч, ухаан уужим шинжлэл төгөлдөр гавж Агваан-чойдог болой.

Үүнээ шүтснээс ч ялгуулсны шашин өнө үүрд оршоод, амьтан бүхэн богд дээдсээр даган баригдаад Очирдарын хутгийг түргэнээ олохуй болтугай. Мангаалам” хэмээн төгсгөжээ.

ДҮГНЭЛТ

Эндээс үзвэл уг зохиол нь дээр дурдснаар анх Гонлүн Жамбаалин хийдийн үлшри ловон Лодойжамцын хувилгааны айлдлыг Пунцагданзанжамц бээр шамдаж дуртгасанд шүтээд, Шакъяагийн аягха тахимлиг Ишбалжир гэдэг хүн улаан нүдэн / модон хулгана/ жилийн зуны дунд сарын цагаан зүгийн ялгуулсан хоёрдугаар өдөр даруй найруулсныг гавж Агваанчойдог бичиж тэмдэглэжээ.

Уг бүтээлийн доторхи агуулгыг ерөнхийд дүгнэн хэлэхэд, Бурханы шашны судар тарнийн утгасыг бүрнээр товчлон оруулснаараа өвөрмөц онцлогтой бөгөөд Бурханы айлдсан бүхий л айлдварын утга санааг ийм нэг дор багтааж, бясалгалын аргачлал болгон оруулсан бүтээл нэн ховор юм.

Тиймээс энэ бүтээл нь бусад мэргэдийн зохиосон ийм төрлийн номоос огт өөр, маш өвөрмөц онцгой зохиол бөгөөд цаашид нарийвчлан судлан шинжилж, орчин цагийн хүмүүст ч багшийг хүндлэх ёсыг нэхэн сургаваас зохистой аж.

Багш хэмээх хүмүүний ачлал гавьяа дуусашгүй их бөгөөтөл багшийн магтан, бясалгасан бурхны энэ мэт ном зохиол ховор тул энэ өгүүллээр та бүхэнд уг зохиолын зөвхөн агуулга төдийг хураангуйлан нэгтгэв. Энэхүү зохиолыг төвөд хэлнээс буулган аливаа утга санааг ойлгон ухаарахад гүнээ тусалсан төвөд хэлт судлаач Ж. Ерөөлт ахад гүнээ талархаж буйгаа эцэст нь айлтгая.

Ашигласан материал

Бадрал (2024). *Сүмбэ хамбын сургаал*. <http://www.baabar.mn/article/3809> (Сүүлд үзсэн: 2024.01.20).

Бира, Ш. (2020). *Төвдөөр бичсэн Монголчуудын түүхийн зохиол*. Өвөр Монголын Ардын Хэвлэлийн Хороо.

Востриков, А.И. (2015). *Төвд хэлээрхи түүхийн зохиол*. Бүрнээ, Д. (орч.). http://www.orientalstudies.ru/rus/images/pdf/b_vostrikov_2015.pdf.

Галаарид, Б. “Монголоо үгүйсгэсэн зурхайн маргаан” *ярилцлага*. <https://www.medeec.mn/p/175889> (Сүүлд үзсэн: 2024.01.20).

Гарри, И. Р., Жабон, Ю. Ж. (2021). «История Кукунора» Сумпа-кенпо Еше Пелджора. *Oriental Studies*. 14. 1. 144–157.

Ишбалжирийн Бурхан шашны түүх (1993). Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо.

Омакаева, Э. У. (1995). *Хальмг зурха. Лит. Бурхн шажна мөргүлин ном* (Калмыцкая астрология. Календарь. Буддийский молитвенник). Элиста.

Пубаев, Р. Е. (1976). Особенности текста исторического сочинения Сумба-хамбо (1704–1788) «Пагсам Чжонсан» и их интерпретация при переводе. *Исследования по истории и филологии Центральной Азии*. Сер. востоковед. 124–127.

Царс, Н. (2015). *Эрдэмт, эмч Ишбалжирын намтар цадиг*. <http://mn.cntv.cn/2015/10/12/ARTI1444631139883743.shtml> (Сүүлд үзсэн: 2024.01.20).

Шү Лин (2016). *Сүмбэ Хамба Ишбалжир*. Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо.

Энхтуяа, Б. (2017). *Монголын уран зохиол 3-5*. <https://enkhee-humanities-darkhan.blogspot.com/2017/02/3-5.html> (Сүүлд үзсэн: 2024.01.20).

J. W. de Jong (1967). Sum-pa mkhan-po (1704–1788) and His Works. *Harvard Journal of Asiatic Studies*. 27. 208–216.

Rosenthal, G. (2004). Biographical research. C. Seale, G. Gobo, J. F. Gubrium, & D. Silverman (Eds.). *Quantitative research practice*. London. 48–64. <https://nbn-resolving.org/urn:nbn:de:0168-ssoar-56725>.

额尔敦白音 (2020). 松巴堪布诗学研究. 内蒙古日报(汉).

References

Badral (2024). *Sumbe khambyn surgaal*. <http://www.baabar.mn/article/3809> (Suld uzsen: 2024.01.20).
Bira, S. (2020). *Tovdoor bichsen Mongolchuudyn tuuhiin zohiol*. Ovor Mongol Ardyn Havlalin Khoroo.
Galaarid, B. (2023). “Mongoloo uguysgesen zurkhain margaan” by yariltslaga. <https://www.medee.mn/p/175889> (uzsen: 2024.01.20).

Garry, I. R., Zhabon, Yu. Zh. (2021). “The Story of Kukunor” by Sumpa-kenpo Yeshe Peljor. *Oriental Studies*. 14. 1. 144–157 (in Russian).

Enkhtuya, B. (2017). *Mongolyn uran zohiol* 3-5. <https://enkhee-humanities-darkhan.blogspot.com/2017/02/3-5.html> (World uzsen: 2024.01.20).

J. W. de Jong (1967). Sum-pa mkhan-po (1704–1788) and His Works. *Harvard Journal of Asiatic Studies*. 27. 208–216.

Ishbaljiriin Burkhan shashny tukh (1993). Oor Mongolin ardyn havlalin khoroo.

Omakaeva, E. U. (1995). *Hal'mg zurkha. Lit. Burkhn shazhna morgulin nom* (Kalmyk astrology. Calendar. Buddhist prayer book). Elista (in Russian and Kalmyk).

Pubaev, R. E. (1976). Features of the text of the historical work Sumba-khambo (1704-1788) “Pagsam Zhongsan” and their interpretation in translation. *Studies on the history and philology of Central Asia*. Ser. Orientalist. 124–127 (in Russian).

Rosenthal, G. (2004). Biographical research. C. Seale, G. Gobo, J. F. Gubrium, & D. Silverman (Eds.). *Quantitative research practice*. London. 48–64. <https://nbn-resolving.org/urn:nbn:de:0168-ssoar-56725>.

Shu Lin (2016). *Sumbe Khamba Ishbaljir*. Ovor Mongol ardyn havlalin khoroo.

Tsars, N. (2015). *Erdamt, emch Ishbaljirin namtar tzadig*. <http://mn.cntv.cn/2015/10/12/ARTI1444631139883743.shtml> (World uzsen: 2024.01.20).

Vostrikov, A.I. (2015). *Tovd halaerhi tuuhiin zohiol*. Burne, D. (orch.). http://www.orientalstudies.ru/rus/images/pdf/b_vostrikov.pdf.